



ОРХОН СУМЫН ЭРҮҮЛ МЭНДИЙН
ТӨВИЙН ДАРГА А.БАТГЭРЭЛ ТАНАА

ДАРХАН-УУЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Бурхантын гудамж-1, 14 дүгээр баг, Дархан сум,
Дархан-Уул аймаг, 45059,
Утас: 7037-3089, Факс: (976) 7037-3089
Цахим шуудан: darkhanuul@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

2026.02.25 № 69

танай _____-ны № _____-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дархан-Уул аймгийн Орхон сумын Эрүүл мэндийн төвийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дархан-Уул аймгийн Орхон сумын Эрүүл мэндийн төвийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Тайлант онд Орхон сумын ИТХ-ын 2025 оны 20 дугаар тогтоолоор Сум хөгжүүлэх сангаас барилгын гадна фасад 287,921.1 мянган төгрөг, Эрүүл мэндийн газраас 3,499.1 мянган төгрөгийн зүрхний цахилгаан бичлэгийн төхөөрөмж үнэ төлбөргүй хүлээн авч, санхүүгийн тайлангийн тодруулгад толилуулсан байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Тайлант онд шатахуун зарцуулалтад жолоочийн тооцооны хуудас дээр шатахуун зарцуулсан ажилтан гарын үсэг зураагүй, нягтлан бодогч хянаж баталгаажуулаагүй, байгууллагын машин тоног төхөөрөмж, тавилга эд хогшил, бусад үндсэн хөрөнгийн ангилалд

452050192

байгаа хөрөнгүүдийг биетээр оршин байгаа хөрөнгүүдтэй тулгахад хөрөнгийг кодлоогүй, биет хөрөнгүүдийн тооллогыг чанаргүй хангалтгүй хийсэн, батлагдсан төсвийг зориулалт бусаар зарцуулсан байна.

Бусад асуудал

Төсвийн шууд захирагч бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Аудитыг гүйцэтгэхдээ Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан 2025-2026 онд гүйцэтгэх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн аудитад баримтлах ерөнхий чиглэлийн хүрээнд авсан судалгаанд дүн шинжилгээ хийж, эрсдэл бүхий асуудалд анхаарал хандуулсан болно.

Дархан-Уул аймгийн Орхон сумын Эрүүл мэндийн төв нь 2025 онд 8 зорилт 58 арга хэмжээ төлөвлөж, хэрэгжилтийг 97.0 хувиар тайлагнасан байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ш.МӨНХБАЯР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Дархан-Уул аймгийн Орхон сумын эрүүл мэндийн төвийн 2025 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: ДАА-2026/110/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn Дархан-Уул аймаг 2026 он	Дарга, тэргүүлэх аудитор Ш.Мөнхбаяр: Утас: 70378845 Цахим хаяг: munkhbayarsh@audit.gov.mn Аудитын менежер: У.Батсүрэн Цахим хаяг: batsurenu@audit.gov.mn Ахлах аудитор: С.Батцэцэг Утас: 70373089 Цахим хаяг: battsetsegs@audit.gov.mn Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн: Хаан консалтинг аудит ХХК Гүйцэтгэх захирал: Э.Нандинчимэг Утас: 88883776 Цахим хаяг: khaanconsultingaudit@gmail.com
--	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

1. ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	2
2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	5
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	6
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	8
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	8
2.6 Аудит хийсэн орон нутгийн төсвийн гүйцэтгэлийн тайлан	10
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА	11
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа	11
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин	11
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	11
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд	11
3.4 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	12
3.5.1 Төсвийн төлөвлөлт	12
3.5.2 Төсвийн гүйцэтгэл	12
3.5.3 Нэмэлт төсөв	13
3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн	13
3.5.5 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл	13
4. АУДИТЫН ТАЙЛАН	13
4.1 Ерөнхий зүйл	13
4.2 Материаллаг байдал	14
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	14
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	14
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	14
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	15
4.5.1 Завсрын аудитын талаар	15
4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн	15
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	15
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	15
5.1 Төлбөрийн акт	15
5.2 Албан шаардлага	15
5.3 Зөвлөмж	16
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ	17

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт



**ДАРХАН-УУЛ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Бурхантын гудамж-1, 14 дүгээр баг, Дархан сум,
Дархан-Уул аймаг, 45059,
Утас: 7037-3089, Факс: (976) 7037-3089
Цахим шуудан: darkhanuul@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

2026.02.05 № 69

танай _____ -ны № _____ -т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дархан-Уул аймгийн Орхон сумын Эрүүл мэндийн төвийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дархан-Уул аймгийн Орхон сумын Эрүүл мэндийн төвийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Тайлант онд Орхон сумын ИТХ-ын 2025 оны 20 дугаар тогтоолоор Сум хөгжүүлэх сангаас барилгын гадна фасад 287,921.1 мянган төгрөг, Эрүүл мэндийн газраас 3,499.1 мянган төгрөгийн зүрхний цахилгаан бичлэгийн төхөөрөмж үнэ төлбөргүй хүлээн авч, санхүүгийн тайлангийн тодруулгад толилуулсан байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Тайлант онд шатахуун зарцуулалтад жолоочийн тооцооны хуудас дээр шатахуун зарцуулсан ажилтан гарын үсэг зураагүй, нягтлан бодогч хянаж баталгаажуулаагүй, байгууллагын машин тоног төхөөрөмж, тавилга эд хогшил, бусад үндсэн хөрөнгийн ангилалд

452 050181

байгаа хөрөнгүүдийг биетээр оршин байгаа хөрөнгүүдтэй тулгахад хөрөнгийг кодлоогүй, биет хөрөнгүүдийн тооллогыг чанаргүй хангалтгүй хийсэн, батлагдсан төсвийг зориулалт бусаар зарцуулсан байна.

Бусад асуудал

Төсвийн шууд захирагч бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Аудитыг гүйцэтгэхдээ Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан 2025-2026 онд гүйцэтгэх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн аудитад баримтлах ерөнхий чиглэлийн хүрээнд авсан судалгаанд дүн шинжилгээ хийж, эрсдэл бүхий асуудалд анхаарал хандуулсан болно.

Дархан-Уул аймгийн Орхон сумын Эрүүл мэндийн төв нь 2025 онд 8 зорилт 58 арга хэмжээ төлөвлөж, хэрэгжилтийг 97.0 хувиар тайлагнасан байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ш.МӨНХБАЯР

2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/Төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	-	3,716,873.95
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	-	3,716,873.95
31211	Төрийн сангийн харилцах	-	3,716,873.95
33	АВЛАГА	128,520,952.80	2,546,412.70
331	Ажиллагчидтай холбогдсон авлага	3,181,469.60	-
332	Төлбөртэй үйлчилгээний авлага	125,339,483.20	2,546,412.70
35	БАРАА МАТЕРИАЛ	119,613,150.72	55,937,755.50
351	Түүхий эд материал	75,954,418.49	26,973,715.76
35110	Тусгай зориулалттай материал	6,044,600.00	9,325,600.00
35130	Эм боох материал	69,909,818.49	17,648,115.76
354	Хангамжийн материал	43,658,732.23	28,964,039.74
35410	Бичиг хэргийн материал	968,750.00	835,750.00
35420	Аж ахуйн материал	42,408,548.23	27,302,700.53
35440	Түлш, шатах тослох материал	225,228.00	721,917.71
35460	Хүнсний материал	56,206.00	103,671.50
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	248,134,103.52	62,201,042.15
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	768,880,906.94	997,913,349.93
392	Биет хөрөнгө	764,080,906.94	993,113,349.93
39201	Барилга, байгууламж, орон сууц	498,438,445.00	786,359,542.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	(66,259,307.01)	(82,102,182.99)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	261,835,800.47	230,399,366.47
39204	Хуримтлагдсан элэгдэл	(69,289,342.86)	(53,797,877.18)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	285,579,537.79	277,455,497.79
39206	Хуримтлагдсан элэгдэл	(171,878,091.91)	(191,598,871.18)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	40,244,310.00	44,357,510.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(20,872,935.12)	(23,147,590.08)
39209	Зам, гүүрийн байгууламж	4,000,000.00	4,000,000.00
39210	Хуримтлагдсан элэгдэл	(2,866,667.24)	(3,066,667.28)
39214	Бусад үндсэн хөрөнгө	12,651,510.00	11,751,510.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(7,502,352.18)	(7,496,887.62)
393	Биет бус хөрөнгө	4,800,000.00	4,800,000.00
39301	Програм хангамж	1,124,300.00	1,124,300.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(1,124,300.00)	(1,124,300.00)
39303	Бусад биет бус хөрөнгө	4,800,000.00	4,800,000.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	768,880,906.94	997,913,349.93
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	1,017,015,010.46	1,060,114,392.08
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	86,625,132.00	35,469,975.70
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	86,625,132.00	35,469,975.70
413	Өглөг	86,625,132.00	35,469,975.70
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	74,315,923.95	34,398,163.70
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	12,161,208.05	571,812.00
4136	Бусад өглөг	148,000.00	500,000.00
41361	Байгууллагад төлөх өглөг	148,000.00	500,000.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	930,389,878.46	1,024,644,416.38
51	Засгийн газрын хувь оролцоо	930,389,878.46	1,024,644,416.38
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	156,678,198.05	156,678,198.05
512	Хуримтлагдсан үр дүн	353,439,657.13	447,694,195.05
51210	Өмнөх үеийн үр дүн	344,720,395.55	353,439,657.13
51220	Тайлант үеийн үр дүн	8,719,261.58	94,254,537.92
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	420,272,023.28	420,272,023.28
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	1,017,015,010.46	1,060,114,392.08

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,197,378,913.03	1,491,686,287.11
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	234,955,333.93	385,937,917.91
120	Нийтлэг татварын бус орлого	234,955,333.93	385,937,917.91
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	8,004,000.00	87,114,194.72
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	3,697,831.72
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	8,004,000.00	83,416,363.00
120009	Бусад орлого		70,000.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	218,415,284.93	298,382,197.00
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	8,536,049.00	371,526.19
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	962,423,579.10	1,105,748,369.20
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	69,051,500.00	76,642,300.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	69,051,500.00	76,642,300.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	893,372,079.10	1,029,106,069.20
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	893,372,079.10	1,029,106,069.20
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,123,659,651.45	1,397,071,809.11
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,123,659,651.45	1,397,071,809.11
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,094,380,406.10	1,291,131,715.60
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	729,084,243.11	871,647,143.18
210101	Үндсэн цалин	359,459,000.03	460,485,503.32
210102	Нэмэгдэл	290,032,083.08	297,239,722.48
210103	Унаа хоолны хөнгөлөлт	12,416,000.00	19,467,423.07
210104	Урамшуулал	67,177,160.00	94,454,494.31
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	89,562,307.01	107,538,857.59
210201	Тэтгэврийн даатгал	60,934,661.89	73,954,293.22
210202	Тэтгэмжийн даатгал	7,366,524.59	8,876,059.94
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,815,020.55	5,443,571.58
210204	Ажилгүйдлийн даатгал	3,289,219.98	4,073,368.29
210205	Эрүүл мэндийн даатгал	13,156,880.00	15,191,564.56
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	37,049,754.65	43,044,369.49
210301	Гэрэл, цахилгаан	7,299,581.65	8,777,828.85
210302	Түлш, халаалт	27,585,793.00	31,563,624.64
210303	Цэвэр, бохир ус	2,164,380.00	2,702,916.00
2104	Хангамж, бараа материалын зардал	29,738,382.40	49,617,183.99
210401	Бичиг хэрэг	5,566,280.00	10,887,187.00
210402	Тээвэр, шатахуун	10,662,143.00	14,503,310.29
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,894,395.40	3,009,634.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	120,000.00	830,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	10,495,564.00	20,387,052.70
2105	Нормативт зардал	114,320,938.22	116,233,765.42
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	97,682,372.42	98,951,088.92

210502	Хоол, хүнс	14,399,565.80	14,192,676.50
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	2,239,000.00	3,090,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	13,427,760.00	15,417,185.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	779,000.00	-
210604	Урсгал засвар	12,648,760.00	15,417,185.00
2107	Томилолт, зочны зардал	434,000.00	164,000.00
210702	Дотоод албан томилолт	434,000.00	164,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,948,886.00	1,668,537.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,006,400.00	771,100.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	720,000.00	720,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	124,749.00	-
210804	Тээврийн хэрэгслийн татвар	97,737.00	158,437.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	-	10,000.00
210807	Газрын төлбөр		4,600.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх		4,400.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	77,814,134.71	85,800,673.93
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	513,180.00	4,110,900.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	77,300,954.71	81,689,773.93
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	29,279,245.35	105,940,093.51
2132	Бусад урсгал шилжүүлэг	8,004,000.00	83,416,363.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	-	57,946,363.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	8,004,000.00	25,470,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	21,275,245.35	22,523,730.51
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	21,275,245.35	22,523,730.51
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	<u>73,719,261.58</u>	<u>94,614,478.00</u>
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	65,000,000.00	359,940.08
225005	Үнэ төлбөргүй гарсан зардал	65,000,000.00	359,940.08
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	(65,000,000.00)	(359,940.08)
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	<u>8,719,261.58</u>	<u>94,254,537.92</u>

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	<u>857,894,820.90</u>	<u>1,315,725,634.42</u>
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	8,004,000.00	87,184,194.72
120	Нийтлэг татварын бус орлого	8,004,000.00	87,184,194.72
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	8,004,000.00	87,114,194.72
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих		3,697,831.72
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	8,004,000.00	83,416,363.00
120009	Бусад орлого		70,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	849,890,820.90	1,228,541,439.70
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	69,051,500.00	76,642,300.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	69,051,500.00	76,642,300.00

1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	780,839,320.90	1,151,899,139.70
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	780,839,320.90	1,151,899,139.70
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	958,808,552.63	1,299,308,800.47
21	УРСГАЛ ЗАРДАЛ	958,808,552.63	1,299,308,800.47
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	929,529,307.28	1,193,368,706.96
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	680,240,828.63	903,556,265.58
210101	Үндсэн цалин	304,051,369.94	492,394,625.72
210102	Нэмэгдэл	297,533,228.82	297,239,722.48
210103	Унаа хоолны хөнгөлөлт	11,601,689.96	19,467,423.07
210104	Урамшуулал	67,054,539.91	94,454,494.31
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	62,072,899.83	111,866,025.84
210201	Тэтгэврийн даатгал	42,209,100.00	81,913,926.00
210202	Тэтгэмжийн даатгал	4,965,699.87	7,488,000.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,483,399.96	3,743,999.84
210204	Ажилгүйдлийн даатгал	2,483,400.00	3,744,000.00
210205	Эрүүл мэндийн даатгал	9,931,300.00	14,976,100.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	37,049,754.65	43,044,369.49
210301	Гэрэл, цахилгаан	7,299,581.65	8,777,828.85
210302	Түлш, халаалт	27,585,793.00	31,563,624.64
210303	Цэвэр, бохир ус	2,164,380.00	2,702,916.00
2104	Хангамж, бараа материалын зардал	24,425,403.40	37,470,587.00
210401	Бичиг хэрэг	3,691,450.00	10,003,220.00
210402	Тээвэр, шатахуун	8,900,000.00	15,000,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,894,395.40	3,009,634.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	120,000.00	830,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	8,819,558.00	8,627,733.00
2105	Нормативт зардал	103,082,594.77	75,025,877.05
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	85,929,900.82	57,493,605.00
210502	Хоол, хүнс	14,667,693.95	14,138,572.05
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	2,485,000.00	3,393,700.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	17,812,160.00	16,462,145.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	641,470.00	-
210604	Урсгал засвар	17,170,690.00	16,462,145.00
2107	Томилолт, зочны зардал	434,000.00	164,000.00
210702	Дотоод албан томилолт	434,000.00	164,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,948,886.00	1,668,537.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,006,400.00	771,100.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	720,000.00	720,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	124,749.00	-
210804	Тээврийн хэрэгслийн татвар	97,737.00	158,437.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	-	10,000.00
210807	Газрын төлбөр		4,600.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх		4,400.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,462,780.00	4,110,900.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,462,780.00	4,110,900.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	29,279,245.35	105,940,093.51
2132	Бусад урсгал шилжүүлэг	8,004,000.00	83,416,363.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	-	57,946,363.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	8,004,000.00	25,470,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	21,275,245.35	22,523,730.51
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	21,275,245.35	22,523,730.51

3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>(100,913,731.73)</u>	<u>16,416,833.95</u>
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	3,909,980.00	12,699,960.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	3,909,980.00	12,699,960.00
2200	Дотоод эх үүсвэрээр	3,909,980.00	12,699,960.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	3,909,980.00	12,699,960.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	<u>(3,909,980.00)</u>	<u>(12,699,960.00)</u>
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	(104,823,711.73)	3,716,873.95
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	104,823,711.73	-
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	3,716,873.95

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
2024 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	156,678,198.05	420,272,023.28	344,720,395.55	921,670,616.88
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	156,678,198.05	420,272,023.28	344,720,395.55	921,670,616.88
Тайлант үеийн үр дүн	-	-	8,719,261.58	8,719,261.58
2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	156,678,198.05	420,272,023.28	353,439,657.13	930,389,878.46
2025 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	156,678,198.05	420,272,023.28	353,439,657.13	930,389,878.46
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	156,678,198.05	420,272,023.28	353,439,657.13	930,389,878.46
Тайлант үеийн үр дүн	-	-	94,254,537.92	94,254,537.92
2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	156,678,198.05	420,272,023.28	447,694,195.05	1,024,644,416.38

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү
1	Татаас, Санхүүжилтын орлого	1,300,567,600.00	1,228,541,439.70	72,026,160.30
133	Төсвийн захирагчдаас			-
134	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	1,223,925,300.00	1,151,899,139.70	72,026,160.30
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	1,223,925,300.00	1,151,899,139.70	72,026,160.30
120004	Төсөвт байгууллагын үйл ажиллагаанаас		87,114,194.72	(87,114,194.72)

1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих		3,697,831.72	(3,697,831.72)
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих		83,416,363.00	(83,416,363.00)
124	Бусад эх үүсвэр			-
1	Үйл ажиллагааны орлогын дүн	1,300,567,600.00	1,315,725,634.42	(15,158,034.42)
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,394,569,300.00	1,235,296,460.47	95,260,499.53
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,300,856,800.00	1,193,368,706.96	107,488,093.04
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	920,913,100.00	903,556,265.58	17,356,834.42
210101	Үндсэн цалин	531,551,500.00	492,394,625.72	39,156,874.28
210102	Нэмэгдэл	250,252,400.00	297,239,722.48	(46,987,322.48)
210103	Унаа хоолны хөнгөлөлт	16,896,000.00	19,467,423.07	(2,571,423.07)
210104	Урамшуулал	122,213,200.00	94,454,494.31	27,758,705.69
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	126,198,300.00	111,866,025.84	14,332,274.16
210201	Тэтгэврийн даатгал	91,053,700.00	81,913,926.00	9,139,774.00
210202	Тэтгэмжийн даатгал	8,786,100.00	7,488,000.00	1,298,100.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,393,100.00	3,743,999.84	649,100.16
210204	Ажилгүйдлийн даатгал	4,393,100.00	3,744,000.00	649,100.00
210205	Эрүүл мэндийн даатгал	17,572,300.00	14,976,100.00	2,596,200.00
2104	Хангамж, бараа материалын зардал	41,637,300.00	37,470,587.00	4,166,713.00
210401	Бичиг хэрэг	11,068,900.00	10,003,220.00	1,065,680.00
210402	Тээвэр, шатахуун	15,876,000.00	15,000,000.00	876,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,025,100.00	3,009,634.00	15,466.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,395,000.00	830,000.00	565,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	10,272,300.00	8,627,733.00	1,644,567.00
2105	Нормативт зардал	111,812,500.00	75,025,877.05	36,786,622.95
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	91,807,100.00	57,493,605.00	34,313,495.00
210502	Хоол, хүнс	16,130,400.00	14,138,572.05	1,991,827.95
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	3,875,000.00	3,393,700.00	481,300.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	17,667,800.00	17,104,205.00	563,595.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	11,039,900.00	11,039,960.00	(60.00)
210602	Тавилга	2,000,000.00	746,300.00	1,253,700.00
210604	Урсгал засвар	4,627,900.00	5,317,945.00	(690,045.00)
2107	Томилолт, зочны зардал	750,200.00	164,000.00	586,200.00
210702	Дотоод албан томилолт	750,200.00	164,000.00	586,200.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	3,843,800.00	2,582,237.00	1,261,563.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,246,000.00	1,684,800.00	561,200.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	800,000.00	720,000.00	80,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	250,000.00		250,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	200,000.00	158,437.00	41,563.00

210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	150,000.00		150,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	43,400.00	10,000.00	33,400.00
210807	Газрын төлбөр	100,000.00	4,600.00	95,400.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	50,000.00		50,000.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	4,400.00	4,400.00	-
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	5,266,500.00	4,110,900.00	1,155,600.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	5,266,500.00	4,110,900.00	1,155,600.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	0.00	0.00	-
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	49,487,400.00	45,172,320.00	4,315,080.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	93,712,500.00	83,416,363.00	10,296,137.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	67,792,500.00	57,946,363.00	9,846,137.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	25,920,000.00	25,470,000.00	450,000.00
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	0.00	
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	3,716,873.95	

2.6 Аудит хийсэн орон нутгийн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	76,642,300.00	54,188,569.49	22,453,730.51
21	УРСГАЛ ЗАРДАЛ	76,642,300.00	54,188,569.49	22,453,730.51
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	76,642,300.00	54,188,569.49	22,453,730.51
2103	БАЙР АШИГЛАЛТАЙ ХОЛБООТОЙ ТОГТМОЛ ЗАРДАЛ	64,617,300.00	43,044,369.49	21,572,930.51
210301	Гэрэл, цахилгаан	12,044,600.00	8,777,828.85	3,266,771.15
21302	Түлш халаалт	47,822,800.00	31,563,624.64	16,259,175.36
21303	Цэвэр, бохир ус	4,749,900.00	2,702,916.00	2,046,984.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	12,025,000.00	11,144,200.00	880,800.00
	Урсгал засвар	12,025,000.00	11,144,200.00	880,800.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	76,642,300.00	54,188,569.49	-
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	0.00	0	-
131103	ЗГНХ, ЗДНХөрөнгө, түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	0.00		

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Дархан-Уул аймгийн Орхон сумын эрүүл мэндийн төвийн эрхэм зорилго нь Эрүүл мэндийн төвийн бүх төрлийн нөөцийг чадавхжуулан, хүн ам ялангуяа зорилтот бүлгийн иргэдийн эргэлт хэрэгцээнд тулгуурласан эрүүл мэндийн тусламж үйлчилгээг чанар, үр дүн, хүртээмжтэй үзүүлж, хүн амын амьдралын чанарыг дээшлүүлэхэд оршино.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тус газар нь Төсвийн тухай хууль, Төрийн албаны тухай хууль, Хөдөлмөрийн тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль, Шилэн дансны тухай хууль, Татварын ерөнхий хууль, Нийгмийн даатгалын ерөнхий хууль болон холбогдох дүрэм, журмыг үйл ажиллагаандаа мөрдөж байна.

Тайлант хугацаанд Төрийн албаны тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль зэрэг үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт орсон байна.

Төсвийн шууд захирагч зарлагын гүйлгээнд гарын үсэг зурснаар дотоод хяналтыг хэрэгжүүлж байгаа бол аймгийн Санхүү, төрийн сангийн хэлтэс холбогдох санхүүгийн баримт материал, гэрээ, гүйцэтгэлийн баримт бичгийг хянаж, зарлагын гүйлгээг хийж байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг үр нөлөөтэй гэж тодорхойлон, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэх шаардлагагүй гэж үзсэн.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Орхон сумын Эрүүл мэндийн төв нь 2025 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Байгууллагын мөрдөж буй Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг Эрүүл мэндийн төвийн даргын 2021 оны А/02 дугаар тушаалаар баталж, мөн оны 1 дүгээр сараас мөрдөж эхэлсэн бөгөөд нягтлан бодох бүртгэлийн стандарт, санхүүгийн программтай нийцсэн байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Дархан-Уул аймгийн Орхон сумын Эрүүл мэндийн төв нь 2025 оны санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1-д заасан бүрэлдэхүүнээр, Сангийн сайдын 2025 оны А/3 дугаар тушаалаар баталсан "Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам"-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 43,099.4 мянган төгрөгөөр буюу 4.2 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	-	3,716.8	3,716.8
Авлага	128,520.9	2,546.4	(125,974.5)
Бараа материал	119,613.1	55,937.7	(63,675.4)
Үндсэн хөрөнгө	768,880.9	997,913.3	229,032.4
Нийт хөрөнгө	1,017,014.9	1,060,114.2	43,099.3
Өр төлбөр	86,625.1	35,469.9	(51,155.2)
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	930,389.8	1,024,644.4	94,254.6
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	1,017,014.9	1,060,114.3	43,099.4

Дээрх хүснэгтээс харахад дансны үлдэгдэлд гарсан материаллаг дүнтэй дараах өөрчлөлт гарчээ. Үүнд:

Тайлант хугацаанд мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл 3,716.8 мянган төгрөг болж 3,716.8 мянган төгрөгөөр өссөн нь төсөвлөсөн зардлаас хэмнэлттэй зарцуулснаас шалтгаалжээ.

Бараа материал дансны үлдэгдэл нь 55,937.7 мянган төгрөг болж 63,675.4 мянган төгрөгөөр буурсан байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 997 913.3 мянган төгрөг болж өмнөх оноос 110 760.6 мянган төгрөгөөр буурсан нь хөрөнгийн элэгдэл 81,689.7 мянган төгрөг тооцсонтой холбоотой байна.

Засгийн газрын хувь оролцоо дансны үлдэгдэл 1,024,644.4 мянган төгрөг болж өмнөх оноос 94,254.6 мянган төгрөгөөр өссөн нь тайлант хугацаанд мөнгөн хөрөнгийн дутуу зарцуулалт болон үнэ төлбөргүй хүлээн авсан бараа материал үндсэн хөрөнгөнөөс шалтгаалсан байна.

3.4 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2025 оны төсвийн төсөлд нийт зарлага ба зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг эрүүл мэндийн даатгалын санхүүжилтээс 1,233,925.3 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 76,642.3 мянган төгрөг, нийт зарлагыг 1,394,569.3 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлснийг эрүүл мэндийн даатгалын санхүүжилтийг 365,46.3 төгрөгөөр бууруулж 1,029,106.0 төгрөг, орон нутгийн төсвийг 76,642.3 төгрөгөөр бууруулж 0 төгрөг, нийт 76,642.3 төгрөгөөр баталсан байна.

Тайлант онд төсвийн хуваарьт 3 удаа өөрчлөлт орж, эрүүл мэндийн даатгалын санхүүжилтын төсвийг зардал хооронд шилжүүлсэн тодотгосон бол орон нутгийн төсөвт 1 удаа зардал хооронд тодотгол хийсэн байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 8 хөтөлбөрийн 58 арга хэмжээг санхүүжүүлэхээр төлөвлөсөн байна.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 1,151,899.1 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 76,642.3 мянган төгрөг, үндсэн үйл ажиллагааны орлого 3,697.8 мянган төгрөг, туслах үйл ажиллагааны орлого 83,416.4 мянган төгрөг нийт 1,315,655.6 мянган төгрөгийн санхүүжилт авч, зарлагын гүйцэтгэл 1,289,415.0 мянган төгрөг буюу 93.2 хувьтай зарцуулж, орон нутгийн төсвөөс зарцуулаагүй үлдсэн 22,523.7 мянган төгрөгийг буцаан төвлөрүүлснээр мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл 3,716.8 төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/

д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
71602	Эмнэлгийн тусламж үйлчилгээ	1,410,938.8	1,315,725.5	95,213.3	93.2
80111	Төрийн өмчийн барилгын тогтмол зардал	76,642.3	76,712.3	(70.0)	100.0
80302	Нэг иргэн норматив	838,870.6	795,466.7	43,403.9	94.8
81603	Үндсэн мэргэжлийн тусламжийн үйлчилгээ	273,710.1	233,626.7	40,083.4	85.3
83603	Нэмэлт-Дээд шатны төсвөөс хуваарилсан	221,715.8	209,919.8	11,796.0	94.6

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

Үйлдвэрчний эвлэлийн хамтын гэрээний 4.5 дахь заалтын дагуу 1 өдрийн хоолны хөнгөлөлтийг 3.0 мянган төгрөгөөр баталж, 19,467.4 мянган төгрөг зарцуулсан байна.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Тайлант онд хэрэгжүүлсэн төсөл хөтөлбөр байхгүй.

3.5.5 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Тайлант онд худалдан авах ажиллагаа зохион байгуулах тендерийн цахим системээс ерөнхий гэрээ байгуулсан бэлтгэн нийлүүлэгчдээс эм боох материал 42,384.0 мянган төгрөгийн худалдан авах ажиллагааг зохион байгуулж, бүрэн хэрэгжүүлсэн байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн худалдан авах ажиллагаа нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй гэж дүгнэлээ.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Дархан-Уул аймгийн Орхон сумын Эрүүл мэндийн төвийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд Дархан-Уул аймгийн Орхон сумын Эрүүл мэндийн төв, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн бараа үйлчилгээний зардлын анхан шатны баримтын бүрдэлттэй холбоотой зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг Хаан консалтинг аудит ХХК-ийн аудитор Ч.Баярсайхан, аудиторын туслах Э.Тунгалагтамир нар гүйцэтгэж, чанарын хяналтыг Хаан консалтинг аудит ХХК-ийн чанарын хяналтын менежер Г.Ганцэцэг, Дархан-Уул аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор С.Батцэцэг, аудитын менежер У.Батсүрэн, газрын дарга, тэргүүлэх аудитор Ш.Мөнхбаяр нар тус тус хэрэгжүүлсэн.

Дархан-Уул аймгийн Орхон сумын эрүүл мэндийн төв нь 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Дархан-Уул аймгийн Төрийн аудитын газарт 2026 оны 01 дүгээр сарын 26-ны өдрийн 14 тоот албан бичгээр ирүүлсэн.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2025 оны батлагдсан төсвийг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэлсэн.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2025 оны батлагдсан төсөв 1,299,685.7 мянган төгрөгөөс 1.0 хувиар буюу 12,996.8 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж, шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзлээ.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Тайлант онд улсын төсвөөс зарцуулаагүй үлдэгдэл 9.6 мянган төгрөг төвлөрүүлсэн нь Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулиар тэвчиж болох зардлыг хэмнэх ажлын хүрээнд төсвийн байгууллагуудын санхүүжилт, зарцуулалтын эрхийг хязгаарлаж, гүйцэтгэлээр санхүүжүүлсэнтэй холбоотой байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Тус төвийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд завсрын аудит хийж, нийт 88,318.9 мянган төгрөгийн алдаа зөрчил илрүүлж, жилийн эцсийн аудитаар горим сорил хэрэгжүүлэхэд зөрчлийг арилгасан байна.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар төлбөрийн актыг хариуцагч нараар төлүүлээгүй, үндэслэлгүй нэмэгдэл олгосон зөрчилд 2,449.5 мянган төгрөгийн төлбөрийн акт, өмнөх аудитын зөвлөмж хэрэгжүүлээгүй, урамшууллыг цалин сангаас олгосон зөрчилд 35,353.7 мянган төгрөгийн 2 албан шаардлага, тооцооны дансаар дамжуулаагүй, цалинг бүтэн цагаар болдож олгосон 11,137.3 мянган төгрөгийн 2 зөвлөмжийн хэрэгжилтийг 2025 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн байдлаар тулган шалгахад 100 хувь хэрэгжүүлж ажилласан байна.

Хүснэгт 3 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	2	2,449.5	2	2,449.5	100.0
Албан шаардлага	4	35,353.7	4	35,353.7	100.0
Зөвлөмж	2	11,137.3	2	11,137.3	100.0
Нийт дүн	8	38,535.2	8	38,535.2	100.0

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарах асуудал байхгүй.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 346,686.2 мянган төгрөгийн зөрчил¹ илэрсэн тул 1 төлбөрийн акт, 2 зөвлөмж хүргүүллээ. Үүнд:

5.1 Төлбөрийн акт

1. Тайлант онд байгууллагын хөрөнгөөр айраг, чихэр зэрэг баярын үйл ажиллагааны хүнсийг 1,597.9 мянган төгрөгийн худалдан авч, төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй төлөвлөж, зарцуулах", 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь "Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1-д "Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд дараах зүйлсийг хориглоно", 15.1.7-д "Байгууллагын төсвөөр согтууруулах ундаа худалдан авах" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

5.2 Албан шаардлага

Аудитаар албан шаардлага өгөх зөрчилтэй асуудал илрээгүй болно.

¹ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

5.3.1 Анхан шатны баримттай холбоотой асуудал

Илрүүлэлт:

Шатахуун зарцуулалтыг тулгахад 11,413.8 мянган төгрөгийн жолоочийн тооцооны хуудас дээр шатахуун зарцуулсан ажилтан гарын үсэг зураагүй, нягтлан бодогч хянаж баталгаажуулаагүй нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.1-д "Төсвийн байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааг удирдах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх заалтыг баримталж, анхан шатны баримтыг бүрэн хөтөлж бүртгэлд тусгах.

5.3.2 Хөрөнгийн тооллоготой холбоотой асуудал

Илрүүлэлт:

Байгууллагын машин тоног төхөөрөмж, тавилга эд хогшил, бусад үндсэн хөрөнгийн ангилалд байгаа 333,674.5 мянган төгрөгийн хөрөнгүүдийг биетээр оршин байгаа хөрөнгүүдтэй тулгахад бүртгэлжүүлж кодлоогүй, биет хөрөнгүүдийн тооллогыг чанаргүй хангалтгүй хийсэн нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1-д "Хөрөнгө, төлбөр тооцооны тооллого хийх зохион байгуулалтын асуудлыг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, ерөнхий нягтлан бодогч нар хариуцна", 20 дугаар зүйлийн 20.2.6-д "Эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах", Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 71 дүгээр зүйлийн 71.1-д "Төрийн өмчит хуулийн этгээдийн эрх баригч, ерөнхий нягтлан бодогч нь тооллого эхлэхийн өмнө дараах бэлтгэл хангасан байх үүрэгтэй", 72 дугаар зүйлийн 72.4-д "Тооллогын комисс дараах үүрэгтэй...эд хөрөнгийн тооллогыг тогтоосон хугацаанд үнэн зөв, чанартай явуулж дуусгах" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1 дэх, 20.2.6 дахь хэсгийг баримталж, хөрөнгүүдийг коджуулж, тооллогыг үнэн зөв чанартай зохион байгуулах.

Дээрх тайлангийн 5.1 дэх хэсэгт дурдсан төлбөрийн акт, 5.3 дахь хэсэгт дурдсан зөвлөмжийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5²-д заасны дагуу ирүүлэх, биелэлтийг Дархан-Уул аймаг дахь Төрийн аудитын газарт 2026 оны 05 дугаар сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

² Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс								Тайл бар
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	
Тайлант онд байгууллагын хөрөнгөөр айраг, чихэр зэрэг баярын үйл ажиллагааны хүнсийг 1,597,921.00 төгрөгийн худалдан авч, төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулсан	1	1,597.9	1	1,597.9	-	-	-	-	-	-	
Шатахуун зарцуулалтыг тулгахад жолоочийн тооцооны хуудас дээр шатахуун зарцуулсан ажилтан гарын үсэг зураагүй, нягтлан бодогч хянаж баталгаажуулаагүй	1	11,413.8	-	-	-	-	1	11,413.8	-	-	
Байгууллагын машин тоног төхөөрөмж, тавилга эд хогшил, бусад үндсэн хөрөнгийн ангилалд байгаа 333,674.5 мянган төгрөгийн хөрөнгүүдийг биетээр оршин байгаа хөрөнгүүдтэй тулгахад бүртгэлжүүлж кодлоогүй, биет хөрөнгүүдийн тооллогыг чанаргүй хангалтгүй хийсэн	1	333,674.5	-	-	-	-	1	333,674.5	-	-	
Дүн	3	346,686.2	1	1,597.9	-	-	2	345,088.3	-	-	-